



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Тэшиг ус” ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021/4/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2021 он	Булган аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас:90900910 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 99057478 Цахим хаяг:Enhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Д.Даариймаа Утас:88555089 Цахим хаяг: daariimaado@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	0
4	0
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	0
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тайлан.....	1
3.Аудитын тайлан	2
3.1. Ерөнхий зүйл	2
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	2
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	2
3.4. Материаллаг байдал.....	2
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	3
3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	4
3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа.....	4
3.8. Шилэн дансны мэдээлэл	4
3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	4
3.10. Аудитын илрүүлэлт	5
Залруулсан алдаа	5
3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	5
4. Менежментийн захидал	6
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	10

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.03.15 № 118

Танай _____-ны № _____ т

“ТЭШИГ УС” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ С.БАЯРСАЙХАН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Тэшиг ус” ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Тэшиг ус” ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

006020245

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ДАНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	141186.89	713377.45
1.1.2	Дансны авлага	4110162.09	3503265
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	508737.71	359174.10
1.1.4	Бусад авлага	2449153	2449153
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	15967108	48502730.14
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	23176347.69	55527699.69
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	37464726.23	26687260.23
1.2.2	Биет бус хөрөнгө	162444	162444
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	37627170.23	26849704.23
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	60803517.92	82377403.92
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	58295711.90	80066088.52
2.1.1.2	Цалингийн өглөг	1920584.10	1812480.05
2.1.1.3	Татварын өр	37160046.25	35291001.78
2.1.1.4	НДШ – ийн өглөг		35040.03
2.1.1.5	Богино хугацаат зээл	12739420.31	
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	110115762.56	117204610.38
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	110115762.56	117204610.38
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-49312244.64	-34827206.46
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	-49312244.64	-34827206.46
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	60803517.92	82377403.92

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	261704292.68	284834825.76
2	Борлуулалтын өртөг	62802109.06	81139867.29
3	Нийт ашиг(алдагдал)	198902183.62	203694958.47
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	19571.59	15282.08
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	216829491.50	182183250.35
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	750500	10049493
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-18658236.29	13872307.20
19	Орлогын татварын зардал	1957.16	2152699.02
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-18660193.45	11719608.18
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-18660193.45	11719608.18
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	-18660193.45	11719608.18
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл					-20808832.1	-20808832.1
Залруулсан үлдэгдэл					-20808832.1	-20808832.1
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					-18660193.45	-18660193.45
Өмчид гарсан өөрчлөлт						
Зарласан ногдол ашиг					-9843219.09	-9843219.09
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл					-49312244.64	-49312244.64
Залруулсан үлдэгдэл					-49312244.64	-49312244.64
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					11719608.18	11719608.18
Зарласан ногдол ашиг					2765430	2765430
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл					-34827206.46	-34827206.46

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	297538814	309831943.56
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	297508814	307690598.10
	Бусад мөнгөн орлого	30000	2141345.46
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	217581729.74	262959743.18
	Ажиллагчдад төлсөн	99555240	71539760.92
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	30356916.33	20222744.26
	Бараа материал худалдан авахад төлсөн	43679307	77488058
	Ашиглалтын зардалд төлсөн	370000	26911630
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	19455400	23477958
	Хүүний төлбөрт төлсөн	717500	
	Татварын байгууллагад төлсөн	15901897.41	28823935.19
	Даатгалын төлбөрт төлсөн	1131155	
	Бусад мөнгөн зарлага	18364314	14495656.81
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	68007084.26	46872200.38
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	19571.59	15282.08
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого	19571.59	15282.08
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	19571.59	15282.08
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	3320000	1567618
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3470000	1567618
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив	-150000	
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	72174459	47882909.90
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	72174459	47882909.90
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-68854459	-46315291.90
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-827803.15	572190.56
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	968990.04	141186.89
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	141186.89	713377.45

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2020 оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
A	Үндсэн ба нэмэгдэл цалин	96,130,000.00	72,298,357.00	23,831,643.00	75.2%
	Байгууллагаас төлөх ЭМД, НДШ	12,977,550.00	20,222,744.00	(7,245,194.00)	166.0%
Б	Цахилгааны өөрийн хэрэглээ	28,572,060.00	25,561,688.00	3,010,372.00	89.5%
	Албан томилолт	6,100,000.00	2,809,000.00	3,291,000.00	46.0%
	Утас интернэт, хэвлэлийн зардал	330,000.00	355,000.00	(25,000.00)	107.6%
В	Түлш, шатахуун	9,200,000.00	11,537,284.00	(2,337,284.00)	125.4%
	Нүүрс модны зардал, тээврийн зардал	104,100,000.00	102,916,897.00	1,183,103.00	98.9%
	Ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал	550,000.00	447,000.00	103,000.00	81.3%
	Бичиг хэргийн зардал	632,000.00	862,665.00	(230,665.00)	136.5%
	Хөдөлмөр хамгааллын зардал	3,290,000.00	1,822,127.00	1,467,873.00	55.4%
	Зээлийн төлөлт	11,144,000.00	21,194,836.00	(10,050,836.00)	190.2%
	Лаборатори, шинжилгээний зардал	380,000.00	91,000.00	289,000.00	23.9%
	Гадны үйлчилгээний хөлс	3,290,000.00	4,181,450.00	(891,450.00)	127.1%
	Даатгалын зардал	500,000.00		500,000.00	0.0%
	Хүнсний зардал	6,940,000.00	4,443,490.00	2,496,510.00	64.0%
	Сэлбэг хэрэгслийн зардал	7,050,000.00	3,321,600.00	3,728,400.00	47.1%
	Хангамж	1,800,000.00	7,109,130.00	(5,309,130.00)	395.0%
	Гүйцэтгэх удирдлагын зардал	2,300,000.00	2,844,078.08	(534,780.00)	123.3%
	НӨАТ	23,567,294.00	28,824,307.00	(5,257,013.00)	122.3%
	Нийт зардал	318,852,904.00	310,842,653.08	8,010,250.92	97.4%

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Тэшиг ус” ОНӨААТҮГ 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг захирал Ц.Баярсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 09-нөөс 2020 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном, аудитор Д.Даариймаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

“Тэшиг ус” ОНӨААТҮГ дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Булган аймгийн Тэшиг сумын Төрийн болон аж ахуй нэгж, хэрэглэгчдийг стандартад тохирсон дулаан, цэвэр усаар тасралтгүй хангаж, бохир усыг экологийн тэнцвэрийг хадгалах шалгуурт тохируулан цэвэрлэж байгальд нийлүүлэх үүрэг бүхий “Тэшиг Ус” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /ОНӨААТҮГ/ нь орон нутгийн өмчийг гэрээгээр ашиглах, өөрийн балансад бүртгэгдсэн эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар мөн.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

“Тэшиг ус” ОНӨААТҮГ санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 217581.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 4351.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн суурь үзүүлэлтийг нийт зардлаар сонгож 194385.4 мянган төгрөгөөс 2 хувиар тооцож 3887.7 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Тэшиг ус” ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21573.9 мянган төгрөгөөр буюу 35.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	141.1	713.3	572.2
Авлага	7068.1	6311.6	-756.5
Урьдчилгаа			
Бараа материал	15967.1	48502.7	32535.6
Үндсэн хөрөнгө	37627.2	26849.7	-10777.5
Нийт хөрөнгийн дүн	60803.5	82377.4	21573.9
Өр төлбөр	110115.7	117204.6	7088.9
Эздийн өмч	-49312.2	-34827.2	14485.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	60803.5	82377.4	21573.9

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 713.3 мянган төгрөг болж 572.2 мянган төгрөгөөр буурсан нь кассад 67.5, арилжааны банк дахь харилцах дансанд 645.8 мянган төгрөг үлдсэнээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 6311.6 мянган төгрөг болж 756.5 мянган төгрөгөөр буурсан байна. Авлага дансны үлдэгдэлд 2017 онд үүссэн он дамжсан байгууллагаас авах 1037.8, ажилчдаас авах 2449.2 мянган төгрөгийн авлага байна.

Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй 3487.0 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 48502.7 мянган төгрөг болж 32535.6 мянган төгрөгөөр өссөн нь оны эцэст 37859.6 мянган төгрөгийн нүүрсний үлдэгдэлтэй тайлагнаснаас шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 141975.2 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 26849.7 мянган төгрөг болж 10777.5 мянган төгрөгөөр буурсан нь 11077.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал бодогдсоноос

шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь авлагын барагдуулалтанд авсан 300.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 117204.6 мянган төгрөг болж 7088.9 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагад төлөх өглөг нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Эздийн өмч дансны үлдэгдэл -34827.2 мянган төгрөг болж 14485.0 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Тэшиг ус” ОНӨААТҮГ гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тайлант оны нийт орлогыг 319843.6 мянган төгрөгөөр, нийт зардлыг 318852.9 мянган төгрөгөөр, ашгийг 990.7 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 310004.64 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 310833.35 мянган төгрөгийн зардал гарган, 11719.6 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь дулаан үйлдвэрлэл, цэвэр, бохир ус түгээлтээс бүрджээ.

3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 1, хараат бус 1, нийт 5 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2020 онд 5 удаа зохион байгуулж жилийн санхүүгийн төлөвлөгөө батлах, захирлын гэрээ дүгнэх, орон тоо бууруулах, үйл ажиллагааны тайлан 2 удаа хуралдсан асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд нийт 6400.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 2800.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: ТУЗ-ын даргын цалинг санхүүжүүлсэн байна.

3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс 115 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийн хугацаа болоогүй, 22 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш, орлого зарлагын 109219.8 мянган төгрөгийн 10 мэдээллийг аудитын хугацаанд нөхөн байршуулсан.

3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	1	110.5	1	110.5	100
Албан шаардлага	1	30.0	1	30.0	100
Зөвлөмж	1	8103.2	1	8103.2	100
Нийт дүн	3	8243.7	3	8243.7	100

3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 117687.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 116840.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 846.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Бараа материалын тайланд бэлэн бүтээгдэхүүн, хүнсний материалын тайлан нярвын тайлангаас 3631.5 мянган төгрөгийн зөрүүг залруулав.
2. Тайлант үеийн үр дүн 3066.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, орлогын татварын зардал, өглөгийн дүн 564.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн.
3. Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш, орлого зарлагын 109209.8 мянган төгрөгийн 10 гүйлгээг аудитын хугацаанд нөхөж байршуулсан.
4. Жолоочийн тооцооны хуудасгүй зарцуулсан 254.7 төлбөрийн актыг аудитын хугацаанд барагдуулсан.

3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар бараа материалын өртөг тооцолт, орлого, зарлагыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Нярвын тайланд анхан шатны баримтыг Сангийн сайдын 2017 оны 347 тушаалаар батлагдсан маягтын дагуу гаргадаггүй, Нярвын тайлан, санхүүгийн тодруулга тайлангаас зөрүүтэй, бичиг хэргийн тайланд 300.0 мянган төгрөгийн программын лиценз, 150.0 мянган төгрөгийн компьютер орлогдсон.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

1.3. Өгсөн зөвлөмж

Анхан шатны баримтыг Сангийн сайдын 2017 оны 347 тушаалаар батлагдсан маягтаар бүрдүүлэх, анхан шатны баримтыг үнэн зөв бүрдүүлэх, анхан шатны баримтанд үндэслэн санхүүгийн тайланг гаргах, нярвын тайланд тавих дотоод хяналтыг сайжруулах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн.

2. Бэлэн мөнгөний зарцуулалттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайланд онд бэлэн мөнгөний кассаар дамжин 34776.9 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн ба байгууллагын бодлогын баримт бичгийн 6.2 дахь "100.0.0-1000.0 сая төгрөгийн жилийн батлагдсан төсөвтэй байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээ 500.0-1500.0 мянган төгрөг", 6.3 дахь "Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300.0 мянган төгрөг, тээвэр шатахууны хэмжээ 500.0 мянган төгрөгөөс хэтрэхгүй байна." гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй.

2.2. Эрсдэл:

Бэлэн мөнгөний кассаар их хэмжээний гүйлгээ хийх.

2.3. Өгсөн зөвлөмж

Бэлэн мөнгөний кассын үлдэгдлийг 1500.0 мянган төгрөгөөс хэтрүүлэхгүй байх, бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг хийхээс бусад үед банкны харилцах дансаар гүйлгээг хийх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Харилцахын баримтанд цалингийн шилжүүлгийн задаргааг бүрдүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн "13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан мэдээ буруу илэрхийлэгдэх, дотоод хяналт сулрах

3.3. Өгсөн зөвлөмж

Анхан шатны баримтын бүрдлийг сайжруулж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн "13.7 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн.

4. Эд хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн тооллогын дүн санхүүгийн тайлангийн дүнгээс 366.5 мянган төгрөгөөр зөрүүтэй.

4.2. Эрсдэл:

Бүртгэлтэй хөрөнгийг дутагдуулах.

4.3. Өгсөн зөвлөмж

Тооллогын комисс томилох болон эд хөрөнгийн тооллого хийх ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 72, 73 дугаар зүйл заалтын дагуу бүрэн хийж гүйцэтгэх.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн.

5. Шилэн данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс 115 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийн хугацаа болоогүй, 22 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш, орлого зарлагын 10 гүйлгээг байршуулаагүй.

5.2. Эрсдэл:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэхгүй байх.

5.3. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн.

6. Программ хангамжтай холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн программ бараа материалын тайлан гаргадаггүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй байна.

6.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

6.3. Өгсөн зөвлөмж:

Бараа материалын тайлан гаргадаг санхүүгийн программ хангамжтай болох.

6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Д.ДААРИЙМАА

6.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

6.3. Өгсөн зөвлөмж:

Бараа материалын тайлан гаргадаг санхүүгийн программ хангамжтай болох.

6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг хүлээн зөвшөөрсөн.


Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ


ХЯНАСАН


ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ДАНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР  Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

 Д.ДААРИЙМАА



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	“Тэшиг-ус” ОНӨААТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2020			БУА-2021/4/СТА-ОНӨААН
Шалгагдсан байгууллагын нэр:	“Тэшиг-ус” ОНӨААТҮГ		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуул-лагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн программ бараа материалын тайлан гаргадаггүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй.	0	Бараа материалын тайлан гаргадаг санхүүгийн программ хангамжтай болох зөвлөмж өгөх.	Захирал, Нягтлан бодогч	С.Баярсайхан, Э.Оюун-Эрдэнэ
2	Няравын тайланд анхан шатны баримтыг Сангийн сайдын 2017 оны 347 тушаалаар батлагдсан маягтын дагуу гаргадаггүй, Няравын тайлан, санхүүгийн тодруулга тайлангаас зөрүүтэй, бичиг хэргийн тайланд 300.0 мянган төгрөгийн программын лиценз, 150.0 мянган төгрөгийн компьютер орлогдсон.	480.0	Анхан шатны баримтыг Сангийн сайдын 2017 оны 347 тушаалаар батлагдсан маягтаар бүрдүүлэх, анхан шатны баримтыг үнэн зөв бүрдүүлэх, анхан шатны баримтанд үндэслэн санхүүгийн тайланг гаргах, няравын тайланд тавих дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж өгөх.	Захирал, Нягтлан бодогч	С.Баярсайхан, Э.Оюун-Эрдэнэ
3	Тайланд онд бэлэн мөнгөний кассаар дамжин 34776.9 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн ба байгууллагын бодлогын баримт бичгийн 6.2 дахь "100.0.0-1000.0 сая төгрөгийн жилийн батлагдсан төсөвтэй байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээ 500.0-1500.0 мянган төгрөг", 6.3 дахь "Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300.0 мянган төгрөг, тээвэр шатахууны хэмжээ 500.0 мянган төгрөгөөс хэтрэхгүй	0	Бэлэн мөнгөний кассын үлдэгдлийг 1500.0 мянган төгрөгөөс хэтрүүлэхгүй байх, бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг хийхээс бусад үед банкны харилцах дансаар гүйлгээг хийх зөвлөмж өгөх.	Захирал, Нягтлан бодогч	С.Баярсайхан, Э.Оюун-Эрдэнэ

	байна." гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй.				
	Харилцахын баримтанд цалингийн шилжүүлгийн задаргааг бүрдүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн "13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.	0	Анхан шатны баримтын бүрдлийг сайжруулж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн "13.7 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх.	Захирал, Нягтлан бодогч	С.Баярсайхан, Э.Оюун-Эрдэнэ
	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс 115 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийн хугацаа болоогүй, 22 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш, орлого зарлагын 10 аудитын хугацаанд нөхөж байршууллаа.	0	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх.	Захирал, Нягтлан бодогч	С.Баярсайхан, Э.Оюун-Эрдэнэ
	Үндсэн хөрөнгийн тооллогын дүн санхүүгийн тайлангийн дүнгээс 366.5 мянган төгрөгөөр зөрүүтэй.	366.5	Тооллогын комисс томилох болон эд хөрөнгийн тооллого хийх ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 72, 73 дугаар зүйл заалтын дагуу бүрэн хийж гүйцэтгэх зөвлөмж өгөх.	Захирал, Нягтлан бодогч	С.Баярсайхан, Э.Оюун-Эрдэнэ
ДҮН					